

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/017/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261663 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

2025.03.25 № 01/1212
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Дамжуулан зээлээр олгосон өмнөх оны авлагаас 2.3 хувь буюу 480.2 сая төгрөг барагдаж, 20,268.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй;
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн "Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд арилжааны 2 банкаар дамжуулан 13,000.0 сая төгрөгийн жижиг зээлийг 579 иргэн, аж ахуй нэгжид зориулалтын дагуу олгосон эсэх, зээлийн ашиглалтад холбогдох журамд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй;
3. Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онд аймаг, нийслэлийн иргэн, аж ахуй нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 12,863.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, холбогдох журамд заасны дагуу санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг олон нийтэд мэдээлээгүй;

Z:\Yawsan_Bichigi\2025\0325 SNAG-41.Docx

1525071480

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2003-2017 оны хооронд олгосон жижиг зээлийн 429.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8, 29.9.13, 30.1.6, Төсвийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21, 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.8, Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.3, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.7, 6.4, 6.11-д заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нийт 40,152 иргэн хамрагдсанаас, 21,732 иргэн ажлын байраар хангагдаж 58,610.9 сая төгрөг, хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 16,101 иргэн хамрагдсанаас, 98 иргэн ажлын байраар хангагдаж 950.1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 2,569 иргэн хамрагдсанаас, 828 иргэн ажлын байраар хангагдаж 7,509.8 сая төгрөг, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд 14,948 иргэн хамрагдаж 5,328.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд улсын хэмжээнд зорилтот бүлгийн нийт 60,406 иргэн хамрагдсанаас 54 хувь буюу 32,652 эмэгтэй иргэн байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд нийт 668.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах иргэний хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийхэд шаардлагатай аргачлал, үнэлгээний маягтыг боловсруулан батлуулж "Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлт"-ийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн мэргэжилтнүүд иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 13,011 иргэнд хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийж, 5,116 иргэний хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх төлөвлөгөөг боловсруулсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САМБУУНЯМ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		243,587,818.0	362,359,313.2
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	243,587,818.0	362,322,763.2
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	-	36,550.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		243,587,818.0	362,359,313.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР		22,871,610.3	30,060,809.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	20,147,446.2	17,446,743.4
Өглөг	17а, 17б	45,346.0	14,192.9
Урьдчилж орсон орлого	18а, 18б	20,102,100.2	17,432,550.4
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,724,164.1	12,614,066.2
Урт хугацаат зээл	20а, 20б	2,724,164.1	12,614,066.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		220,716,207.7	332,298,503.6
Засгийн газрын хувь оролцоо		220,716,207.7	332,298,503.6
Хуримтлагдсан үр дүн		220,716,207.7	332,298,503.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		243,587,818.0	362,359,313.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		182,278,180.6	144,860,556.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	158,220,758.9	144,732,551.7
Нийтлэг татварын бус орлого		158,220,758.9	144,732,551.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		24,057,421.0	128,005.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	114,482,482.40	23,656,463.8
УРСГАЛ ЗАРДАЛ		114,482,482.4	23,656,463.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,611,408.8	4,414,523.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,554,941.8	4,286,780.7
Бараа үйлчилгээний бусад зардал		56,467.0	127,743.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		109,871,073.0	19,241,940.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		67,795,698.2	121,204,092.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		76,508.3	9,547,307.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		67,719,189.9	111,656,785.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,993,935.8	-	152,993,935.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,082.0	-	3,082.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,997,017.8	-	152,997,017.8
Тайлант үеийн үр дүн	67,719,189.9	-	67,719,189.9
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,716,207.7	-	220,716,207.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(74,490.0)	-	(74,490.0)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,641,717.7	-	220,641,717.7
Тайлант үеийн үр дүн	111,656,785.9	-	111,656,785.9
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,298,503.6	-	332,298,503.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	258,264,318.1	269,197,920.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	197,787,753.1	242,840,693.3
Нийтлэг татварын бус орлого	197,787,753.1	242,840,693.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,476,565.0	26,357,227.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	258,261,018.1	259,650,613.9
УРСГАЛ ЗАРДАЛ	258,261,018.1	259,650,613.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,646,594.8	4,373,816.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,585,127.8	4,246,201.7
Бараа үйлчилгээний бусад зардал	61,467.0	127,615.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,614,423.3	255,276,797.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)- (II)	3,300.0	9,547,307.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,300.0	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,300.0	-
Дотоод эх үүсвэрээр	3,300.0	-
Гадаад эх үүсвэрээр	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,300.0)	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(9,547,307.0)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	9,547,307.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,275,055,100.0	84,210,251,579.4	64,803,520.6	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	94,033,870,100.0	74,662,944,630.1	19,370,925,469.9	79.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,561,256,000.0	4,246,201,731.2	5,315,054,268.8	44.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,561,256,000.0	4,246,201,731.2	5,315,054,268.8	44.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,561,256,000.0	4,246,201,731.2	5,315,054,268.8	44.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,472,614,100.0	70,416,742,898.9	14,055,871,201.1	83.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,472,614,100.0	70,416,742,898.9	14,055,871,201.1	83.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	84,472,614,100.0	70,416,742,898.9	14,055,871,201.1	83.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(9,758,815,000.0)	9,547,306,949.3	211,508,050.7	97.8
230001	Эргэж төлөгдөх зээл	(22,758,815,000.0)	(3,452,693,050.7)	19,306,121,949.3	15.2
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	13,000,000,000.0	13,000,000,000.0	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84,275,055,100.0	268,995,744,446.3	(184,720,689,346.3)	319.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	84,275,055,100.0	242,766,521,942.8	(158,491,466,842.8)	288.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,275,720,100.0	117,885,896,766.5	(96,610,176,666.5)	554.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,496,950,000.0	10,618,601,274.3	(7,121,651,274.3)	303.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	46,502,385,000.0	101,262,023,902.0	(54,759,638,902.0)	217.8
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	13,000,000,000.0	13,000,000,000.0	-	100.0
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	26,229,222,503.5	(26,229,222,503.5)	
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	26,229,222,503.5	(26,229,222,503.5)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	124,255,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	124,255,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	123,865,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	123,865,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	123,865,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	390,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	390,000.0
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	390,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	124,255,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	124,255,000.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	109,250,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	15,005,000.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 34 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 16 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 11 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгч, 6 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитаар нийт 51,131.0 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 37 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитаар нийт 65,691.3 сая төгрөгийн 79 зөрчил² илэрснээс 8.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 58,675.4 сая төгрөгийн зөрчилд 30 албан шаардлага хүргүүлж, 6,211.1 сая төгрөгийн зөрчилд 40 зөвлөмж өгч, 147.1 сая төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 849.7 сая төгрөгийн зөрчилд 4 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 65,891.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 65,654.8 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Харьяа сангуудын санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 28,998.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10,765.8 сая төгрөгийн алдааг залруулж, 8.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 11,655.5 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага, 5,562.5 сая төгрөгийн зөрчилд 39 зөвлөмж, 147.1 сая төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 849.7 сая төгрөгийн зөрчилд 4 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

Төвлөрүүлэн захирагч /ЗГТС/

Аудитаар нийт 47,658.4 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 47,009.8 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 648.5 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Албан шаардлага

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвөөс 263.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- ХЭДС-ийн харьяаны бус байгууллага БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд 200.0 сая төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүй шилжүүлсэн;
- ХХҮЕГ-ын байгууллагын удирдах ажилтны хэлэлцүүлэг зохион байгуулах зардалд 14.9 сая төгрөг, дотоод албан томилолт, шатахууны зардалд 23.3 сая төгрөг, программын лицензийн төлбөрт 19.2 сая төгрөг, ХХҮЕГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэвлэлийн зардалд 6.0 сая төгрөгийг зориулалт бус зардалд зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 6.6.2-д "төсвийн захирагч нь

төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;" 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, сангийн чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болголгүй ХХҮЕГ-ын үйл ажиллагааны хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын 89.2 сая төгрөгийн нэг төрлийн ижил бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг 9 хуваан шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж, санхүүжилтийг гэрээ дүгнэхээс өмнө шилжүүлсэн байна.

Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримтлаагүй нэг төрлийн ажил, үйлчилгээг 2 хуулийн этгээдтэй нийт 40.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон.

Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжээр эмэгтэйчүүдэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөх үйлчилгээний ажлын зардалд 19.8 сая төгрөг, мөн өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг нөхөрлөлийн байгууллагаар малжуулах ажлыг зохион байгуулах зөвлөх үйлчилгээний зардалд 19.5 сая төгрөгийг тус тус олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", 17 дугаар зүйлийн 17.2.1-д "ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;" 17.2.2-д "бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг баримтлаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй, шууд худалдан авалт хийсэн, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилтээр Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /хуучин нэрээр/ болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу "Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд 2 банкаар 13,000.0 сая төгрөгийн төгрөгийн жижиг зээлийг 579 иргэн, аж ахуй нэгжид Нийслэлд 8.4 хувь, орон нутагт 6.0 хувийн хүүтэй 36 сарын хугацаатай дамжуулан зээлдүүлсэн байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан чиглэл, зорилтот арга хэмжээнд олгож байгаа эсэх, зээлдэгчийн зээлийн гэрээний хэрэгжилт болон зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд холбогдох журамд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, мөн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.10, 6.11-д заасны дагуу жижиг зээлд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулж олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.3-д "дэд зээлдэгчид төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар тайлан, мэдээллийг тогтмол хүргүүлэх, эдгээр тайлан, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд хариуцлага хүлээх.", Засгийн газрын 2011 оны 375 тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ.", 5.3-д "Сангийн зарцуулалтад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналт, ... тус тус эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.", Засгийн газрын 2021 оны 340 дүгээр "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.25-д "Зээлийн гэрээг зөрчсөн болон зээлээ төлж дууссан боловч ашиглалтын явцад зээлийг зориулалтын бусаар зарцуулсан нь тогтоогдсон зээлдэгчид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээлийг дахин олгохгүй.", 6 дугаар зүйлийн 6.3-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 6.1-д заасан мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулж, мэдээллийн сан үүсгэж олон нийтэд мэдээлнэ.", 6.6-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, дүүргийн салбар зөвлөл хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд уг үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар хяналт, шалгалт хийлгэж болно.", 6.10-д "Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.", 6.11-д "Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2011 оны 375, 2021 оны 340 дүгээр тогтоолуудыг баримталж ажиллаагүй, жижиг зээлд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулж олон нийтэд ил тод мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онуудад орон нутаг, нийслэлийн иргэн аж, ахуй нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн нийт 15,505.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 17.0 хувь буюу 2,642.1 сая төгрөгийн зээл барагдаж, 12,863.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдаагүй гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, холбогдох журамд заасны дагуу зээлийг эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийг олон нийтэд мэдээлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.7-д “Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлан мэдээг гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэнэ”, 6 дугаар зүйлийн 6.11-д “Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ.” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийг олон нийтэд мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, авлагыг 40-өөс доошгүй хувиар барагдуулах арга хэмжээг авч ажиллах, цаашид авлагыг барагдуулах талаар үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5. Өмнөх оны аудитаар өгсөн 20,837.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Дамжуулан зээлийн өмнөх оны авлагаас 2.3 хувь буюу 480.2 сая төгрөг барагдаж нийт 20,268.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Тухайлбал:

1. Оёдлын нэгдсэн холбоонд 2013 онд олгосон нийт 16,083.4 сая төгрөгийн зээлээс 15,639.8 сая төгрөгийн авлага;
2. Капитал банканд холбогдох хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл нийт 3,856.6 сая төгрөгийн авлагаас 3,829.0 сая төгрөг;
3. Анод банканд 2005-2008 онд байршуулсан 800.0 сая төгрөг;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг барагдуулах талаар харьяа дээд шатны байгууллагатай хамтран төлөвлөгөө боловсруулж, авлагыг 20-оос доошгүй хувиар барагдуулах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлэв.

6. Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам”-ыг үндэслэн 2003-2017 онд олгосон зээлээс нийт 11 иргэн, аж ахуй нэгжийн хугацаа хэтэрсэн Шүүхийн шийдвэртэй 480.4 сая төгрөгийн авлагаас тайлант онд 10.7 хувь буюу 51.4 сая төгрөгийг барагдуулж, 429.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.7-д “Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлан мэдээг гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэнэ”, 6 дугаар зүйлийн 6.11-д “Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ.” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолыг баримталж ажиллаагүй, зээлийг эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийг олон нийтэд мэдээлээгүй, зөрчлийг таслан зогсоож, авлагыг 40-өөс доошгүй хувиар барагдуулах арга хэмжээг авч, албан шаардлага хүргүүлэв.

7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа 33 сангийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 28,998.8 сая төгрөгийн 104 алдаа, зөрчил илэрснээс, санхүүгийн тайлагналтай холбоотой 10,765.8 сая төгрөгийн 32 алдаа, 18,233.0 сая төгрөгийн 72 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 10,541.5 сая төгрөгийн 18 зөрчил илэрсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;”, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор 1 дүгээр хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” 5 дугаар зүйлийн 5.1-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ.”, 5.3-д “Сангийн зарцуулалтад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналт, ... тус тус эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.”, 5.4-д “Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

8. Өмнөх оны аудитаар тогтоосон 36.2 сая төгрөг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан зөрчлийг нөхөн төлүүлэхээр тогтоосон төлбөрийн актыг барагдуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21-д “Санхүүгийн дэмжлэг гэж төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор олгох хөрөнгийг”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах, зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлэв.

9. Өмнөх оны аудитаар өгсөн ХЭДС-аас олгосон жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банк сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 2 дугаар хурлаар банканд байршуулсан 20,000.0 сая төгрөгийн эх үүсвэрт жилийн 4.4 хувиар хүү тооцож авахаар шийдвэрлэсэн байна. Жилийн хүүг тооцоолох суурь үзүүлэлтийг 2015-2020 онуудын инфляцын түвшний дундаж болон эрсдэлийн хувийг харьцуулсан гэх боловч тооцоолол хийсэн арга тодорхойгүй, 2021, 2022 оны үзүүлэлтийг авч үзэхгүй, хүүгийн түвшнийг тогтоох арга аргачлал, тооцоолол хийх маягт батлаагүй зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Арилжааны банкаар дамжуулан зээлдүүлэх хүүгийн түвшнийг тогтоох аргачлал, тооцоолол хийх маягыг дээд шатны байгууллагатай хамтран боловсруулж батлуулах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Тайлант онд ХХҮЕГ-ын ХЭДС-ийн хэрэгжүүлэх 25 хөтөлбөр, арга хэмжээнээс 648.5 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 4 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна. Үүнд:

1. Ажил олоход хүндрэлтэй иргэнийг тогтмол ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх - 403.0 сая төгрөг;
2. Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ - 117.0 сая төгрөг;
3. Ахмадын төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ - 85.0 сая төгрөг;
4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх - 43.6 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;”, 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг төлөвлөхдөө үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 117,022.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 51,131.0 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 65,891.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10,577.7 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

4.1.Аудитаар нийт 51,131.0 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	5	40,365,143.8	5	40,365,143.8			5	40,365,143.8				
2	Булган аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	45,405.1	1	26,397.1	1	19,008.0	2	45,405.1				
3	Говь-Алтай аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	4,249.0	1	4,249.0			1	4,249.0				
4	Дорноговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	1,242.6			3	1,242.6	3	1,242.6				
5	Дундговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	11,000.0			1	11,000.0	1	11,000.0				
6	Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	8,205,369.0	2	8,205,369.0			2	8,205,369.0				
7	Ховд аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	63,000.0			1	63,000.0	1	63,000.0				
8	Хэнтий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	551,003.4	2	550,103.4	1	900.0	3	551,003.4				
9	Хан-Уул дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	397,794.0	2	397,794.0			2	397,794.0				
10	Баянзүрх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	29,660.0	1	29,660.0			1	29,660.0				
11	Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	343,536.2	2	44,700.0	2	298,836.2	4	343,536.2				
12	Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	508,976.6	1	27,590.0	1	481,386.6	2	508,976.6				
13	Сүхбаатар дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	39,960.0	1	29,250.0	1	10,710.0	2	39,960.0				
14	Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	10,679.0			1	10,679.0	1	10,679.0				
15	Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	202,621.1			3	202,621.1	3	202,621.1				

16	Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	347,357.7			3	347,357.7	3	347,357.7				
17	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,980.0			1	3,980.0	1	3,980.0				
Дүн		37	51,130,977.5	18	49,680,256.3	19	1,450,721.2	37	51,130,977.5				

4.2 Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 65,891.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 79 зөрчил илэрснээс 8.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 58,675.4 сая төгрөгийн зөрчилд 30 албан шаардлага хүргүүлж, 6,211.1 сая төгрөгийн зөрчилд 40 зөвлөмж өгч, 147.1 сая төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 849.7 сая төгрөгийн зөрчилд 4 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ХЭДС	7	47,658,365.9	-	-	6	47,009,845.9			1	648,520.0		
2	Архангай аймгийн ХЭДС	-	-										
3	Баян-өлгий аймгийн ХЭДС	5	6,401,817.2	1	8,000.0	3	6,393,817.2	1	-				
4	Баянхонгор аймгийн ХЭДС	2	140,165.0			2	140,165.0						
5	Булган аймгийн ХЭДС	1	3,378,552.2							1	3,378,552.2		
6	Говь-Алтай аймгийн ХЭДС	-	-										
7	Дорноговь аймгийн ХЭДС	1	-							1	-		
8	Дорнод аймгийн ХЭДС	-	-										
9	Дундговь аймгийн ХЭДС	-	-										
10	Завхан аймгийн ХЭДС	1	250,229.0			1	250,229.0						
11	Өвөрхангай аймгийн ХЭДС	-	-										
12	Өмнөговь аймгийн ХЭДС	5	12,250.0							5	12,250.0		
13	Сүхбаатар аймгийн ХЭДС	1	28,306.8			1	28,306.8						
14	Сэлэнгэ аймгийн ХЭДС	2	22,804.0			1	9,350.0			1	13,454.0		

15	Төв аймгийн ХЭДС	1	17,203.5						1	17,203.5			
16	Увс аймгийн ХЭДС	-	-										
17	Ховд аймгийн ХЭДС	2	37,268.8						2	37,268.8			
18	Хөвсгөл аймгийн ХЭДС	1	48,913.0						1	48,913.0			
19	Хэнтий аймгийн ХЭДС	-	-										
20	Дархан-Уул аймгийн ХЭДС	-	-										
21	Орхон аймгийн ХЭДС	1	1,609.8						1	1,609.8			
22	Говьсүмбэр аймгийн ХЭДС	3	5,831.4	1	99.5	1	1,636.9		1	4,095.0			
23	Хан-Уул дүүргийн ХЭДС	5	157,791.7			3	77,461.7		2	80,330.0			
24	Багануур дүүргийн ХЭДС	3	426,337.5						3	426,337.5			
25	Баянзүрх дүүргийн ХЭДС	5	382,565.6			2	285,244.3		3	97,321.3			
26	Налайх дүүргийн ХЭДС	4	123,108.0			1	29,700.0		3	93,408.0			
27	Баянгол дүүргийн ХЭДС	5	85,160.5			1	27,590.0		4	57,570.5			
28	Сүхбаатар дүүргийн ХЭДС	3	84,527.9			1	29,250.0		2	55,277.9			
29	Чингэлтэй дүүргийн ХЭДС	2	245,135.0						2	245,135.0			
30	Багахангай дүүргийн ХЭДС	1	18,000.0						1	18,000.0			
31	Сонгинохайрхан дүүргийн ХЭДС	3	918,484.4			1	28,850.0		2	889,634.4			
32	Нийслэлийн ХЭДС	2	9,415.0			1	2,745.0		1	6,670.0			
33	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институт	8	4,508,275.9			5	4,361,175.9				3	147,100.00	
34	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар-Дэмжих сан	5	929,249.0					3	849,749.0	2	79,500.0		
Дүн		79	65,891,367.2	2	8,099.5	30	58,675,367.7	4	849,749.0	40	6,211,050.9	3	147,100.0

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3. Нийцлийн аудиттай холбоотой нийт 10,577.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 7,988.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж, 2,589.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зерчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	36,214.8			3	36,214.8			1	-
2	Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,497,819.7			1	1,497,819.7				
3	Булган аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	2,490,507.4			1	2,490,507.4				
4	Өвөрхангай аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,537,505.6			1	3,537,505.6				
5	Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-							1	-
6	Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-							1	-
7	Ховд аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-							1	-
8	Дархан-Уул аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	2,010,710.0							1	2,010,710.0
9	Орхон аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-							1	-
10	Говьсүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	426,405.0			1	426,405.0				
11	Хан-Уул дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	33,500.0							1	33,500.0
12	Багануур дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	25,105.0							1	25,105.0
13	Баянзүрх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	80,844.0							1	80,844.0
14	Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	83,130.1							1	83,130.1
15	Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	53,680.0							1	53,680.0
16	Сүхбаатар дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	88,182.0							1	88,182.0
17	Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	80,844.0							1	80,844.0
18	Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	7,840.0							1	7,840.0
19	Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	125,405.0							1	125,405.0
Дүн		22	10,577,692.6			7	7,988,452.5	0	-	15	2,589,240.1